



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/182

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 12 дугаар хуралдааны 18 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн “Төв музей”-ээс ирүүлсэн хүсэлтийг харгалзан “Хөвсгөлд зочлох жил”-ийн хүрээнд аймгийн “Төв музей”-д нүүдлийн гэр музей ажиллуулахад шаардлагатай найман ханатай иж бүрэн гэр, урц худалдан авах зардалд 18,000,000 (Арван найман сая), жуулчдад зориулсан түүхэн танхим байгуулахад 5,000,000 (Таван сая) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх 23,000,000 (Хорин гурван сая) төгрөгийн зардлыг Засаг дарга дансны “Хөвсгөлд зочлох жил” нэрлэсэн жилийн арга хэмжээний зардал”-аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Дээрх зардлын хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг аймгийн “Төв музей”-н захирал (Х.Рагчаа)-д даалгасугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

671 1010645